



8

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 3 сарын 28 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Өнгөт гэрэл зургийн "АГФА" төвийг татан буулгах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 46 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Өнгөт гэрэл зургийн "Агфа" төв нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Өнгөт гэрэл зургийн "Агфа" төв нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Жаргалсайханыг 2005 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Гурав. Татан буугдаж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарлах, байгууллага, хувь хүмүүсийн авлага, ер төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, байгууллагын хаалтын балансыг 2005 оны 6 дугаар сарын 1-ний дотор гаргаж, холбогдох байгууллагад тушаахыг татан буулгах комисс /Ж.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

Дөрөв. Байгууллагын бичиг баримтыг архивлан Нийслэлийн Архивын албанд шилжүүлэх, тус төвийн ажиллагсдын асуудлыг Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн дагуу шийдвэрлэхийг татан буулгах комисс /Ж.Эрдэнэбаатар/-т үүрэг болгосугай.

Тав. "Агфа" төвийн өрийн асуудлыг барагдуулах тухай саналыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралд танилцуулах, захирамжийн биелэлтийг хангуулах, түүнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын дэргэдэх Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т даалгасугай.




НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Zaki-05

0200367



Нийслэлийн Засаг даргын 2005 оны 3 дугаар сарын 28 ны өдрийн 104 дугаар захирамжийн хавсралт

Өнгөт гэрэл зургийн "Агфа" төв нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн

- Комиссын дарга: - Ж.Эрдэнэбаатар /Өмчийн газрын хэлтсийн дарга/
- Гишүүдэд:
- Б.Бүрэнцэцэг / Өмчийн газрын мэргэжилтэн/
 - Ц.Оюунгэрэл /Өмчийн газрын мэргэжилтэн/
 - А.Нарантуяа /Өмчийн газрын хуулийн зөвлөх/
 - Д.Жаргалсайхан /Агфа төвийн захирал/
 - Т.Энхтуяа /Агфа төвийн нягтлан бодогч/